

## **ТӨВ АЙМГИЙН 2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 03 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 8-р хуралдааны 06 дугаар тогтоолоор “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл”-ийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд зөвлөлийн Анхдугаар Хуралдаан 03 дугаар хуралдаан 2022 оны 03 дугаар сарын 23-ны хуралдсан.

#### **Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Анхдугаар Хуралдаанаар:-**

1.Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдааны дэгийг хэлэлцэн, аймгийн ИТХ-ын даргын захирамжаар батлав.

2.Аймгийн ИТХ-ын ээлжит бус 3 дугаар Хуралдааны товыг 2022 оны 03-р сарын 28-ны өдөр аймгийн ЗДТГ-ын хуралдааны танхимд хуралдуулахаар тогтож, Хуралдаанаар 4 асуудал хэлэлцүүлэхээр хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоов.

3.Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцээд 6 бүлэг хүрээнд 22 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр аймгийн ИТХ-ын даргын захирамжаар батлав.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус 3 дугаар Хуралдаан 2022 оны 03-р сарын 28-ны өдрийн “Даваа” гаригт аймгийн ЗДТГ-ын Хуралдааны танхимд хуралдлаа.

#### **Аймгийн ИТХ-ын ээлжит бус-3 дугаар Хуралдаанаар:-**

1.”Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хүчингүй болгох тухай” мэдээлэл, түүнд Хурлын Хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоог хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор аймгийн ИТХ-ын 1, Тэргүүлэгчдийн 13 тогтоол хүчингүй болгон “Тогтоол хүчингүй болгох тухай” 01-р тогтоолын хавсралтаар жагсаалтыг батлав.

Орон нутгийн түвшинд батлан хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлуулахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

2.”Олон хүүхэд төрүүлж өсгөн “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах хүсэлт уламжлах тухай” асуудлыг хэлэлцээд “Эхийн алдар” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах болзол хангасан “Эхийн алдар” нэгдүгээр одонгоор 43, “Эхийн алдар” хоёрдугаар одонгоор 326, нийт 27 сумын 369 эхчүүдийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

3. “Нөхөн Сонгууль зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай” асуудлыг хэлэлцээд Төв аймгийн Алтанбулаг, Баянжаргалан сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумдын сонгуулийн хороог мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах “Аймгийн сонгуулийн хороо”-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

4. “Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг зохион байгуулах аймгийн хороо байгуулах тухай” асуудлыг хэлэлцээд Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, Ардын хувьсгалын 102 жил, Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, Зуунмод хот байгуулагдсаны 81 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх үүрэг бүхий “Зохион байгуулах аймгийн хороо”-г аймгийн Засаг даргаар ахлуулан 34 хүний бүрэлдэхүүнтэй байгуулав.

#### **Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:**

3 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 27 албан бичиг ирснээс 3 албан бичгийн хариуг, иргэдээс 7 өргөдөл ирснээс 4 өргөдлийн хариуг хүргүүлсэн. Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 29 бичиг хүргүүлэв.

Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоолын дагуу аймгийн ИТХ-ын 2022 оны 8 дугаар хуралдаанаар аймгийн ИТХ-ын ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн тогтоож, ажлын албаны мэргэжилтнүүдийн албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн зөвшөөрөл авахаар Монгол Улсын Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022 оны 3-р сарын 28-ны өдөр баталсан.

Төв аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, Төв аймгийн Цагдаагийн газартай хамтран Алтанбулаг, Заамар, Баянчандмань сумын төрийн албан хаагчдад шинээр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдлэг олгох, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор хуулийн сэдэвчилсэн сургалтыг 03-р сарын 02, 16, 23-ны өдрүүдэд зохион байгууллаа.

2022 оны 03 сарын 23-25-ны өдрүүдэд Авилгатай тэмцэх газраас Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт бэлтгэгдсэн сургагч багшийг давтан сургах сургалтад 2 мэргэжилтнийг хамруулсан.

#### **Бусад ажлын хүрээнд:**

2022 оны 03-р сарын 11-12-ны өдрүүдэд 27 сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх нь” сургалт зөвлөгөөн зохион байгууллаа. Сургалт, зөвлөгөөний үеэр сумдын ИТХ-уудаас 2021 оны ажлын үзүүлэлт, гүйцэтгэлийн үр дүнгээрээ хамгийн өндөр үнэлгээ авч шалгарсан Эрдэнэ, Зуунмод, Эрдэнэсант сумлын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудад шагнал гардуулав.

2022 оны 03-р сарын 25-ны өдөр аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг Зуунмод хотод ажиллаж Зуунмод сумын түүхт 80 жилийн ой угтсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, явцын мэдээллийг сонслоо.

2022 онд Зуунмод хот үүсэн байгуулагдсаны түүхт 80 жилийн ой тохиож, тэмдэглэлт өдрийг угтан бэлтгэл ажлын хангах ажлын хэсэг байгуулах шийдвэрийг сумын ИТХ-ын тогтоолоор батлуулан ажиллаж байгаа бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд 80-н бүтээлч ажлын жагсаалт, төлөвлөгөөг гарган батлуулж төсвийн болон аж ахуйн нэгж байгууллага, хотын уугуул, суугуул иргэдэд олон нийтэд сурталчлан ажиллаж байгаа талаар Зуунмод хотын Засаг дарга бөгөөд Хотын захирагч Ч.Сарангэрэл мэдээлэл хийв. Аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Саран-Эрдэнэ нар Зуунмод хотын ойг аймгийн 100 жилийн ойтой уялдуулах санал солилцон, холбогдох ажлын чиглэл өглөө.

#### **Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:**

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны Анхдугаар хуралдааныг 03-р сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Тус хуралдаанаар 2021 оны ажлын тайланг хэлэлцэж, сумдын зөвлөлийн шалган туслах ажлын дүн, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл солилцов.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд 28 удаагийн олон талт арга хэмжээ, сургалт сурталчилгаа, сумдад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулж, салбар зөвлөлийн 2021 оны төлөвлөгөө 88 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн анхдугаар хуралдаанаар аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн батлав.

2021 онд аймгийн хэмжээнд 509 холбогдогчтой, 3 тэрбум 742 сая төгрөгийн хохиролтой, 611 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 126 хэргээр буюу -17.1 хувиар буурчээ.

Аймгийн ГХУСАЗСЗ-ийн хуралдаанаар хөндөгдсөн асуудлыг нэгтгэн сумдын ИТХ-ын дарга бөгөөд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын зөвлөлийн дарга нарт ажил эрчимжүүлэх, 2022 онд анхаарах асуудлаар аймгийн ГХУСАЗСЗ-ийн даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 03 тоот албан бичгээр үүрэг, чиглэл хүргүүлээд байна.

**Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:-**

Монгол Улсын Их Хурлын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга С.Одонтуяа 03-р сарын 03-ны өдөр Төв аймагт ажилласан бөгөөд Төв аймгийн ИТХ-ын дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын дарга Ц.Жамбалсүрэн, ИТХ-ын нарийн бичгийн дарга, салбар комиссын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нар хүлээн авч уулзлаа.

Аймгийн ИТХ нь 2020-2021 онд хэлмэгдэгчдийн эхнэр, нөхөр, хүүхэд нийт 39 иргэнд 2.2 тэрбум төгрөгийн нөхөх олговор олгоод байгаагаас гадна улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг санан дурсах, тэдний гэгээн дурсгалыг мөнхжүүлэх ажлыг жил бүрийн 9-р сард зохион байгуулж, 27 сумын ИТХ-д чиглэл өгч ажиллаж байна. Үүнд Хэлмэгдэгсдийн үр хүүхдүүдэд нь хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг өгөх, сүм хийдэд буяны ном хуруулах, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн тэмцээн зохиох, багш нартай хамтран улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийн талаар яриа таниулга хийх зэрэг олон төрлийн арга хэмжээ зохион байгуулж байна.

Уулзалтын үр дүнд цаашид Цагаатгалын үндсэн 3 үйл ажиллагааны чиглэл болох Хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах буюу хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэл төв, орон нутгийн түвшинд хамтарч ажиллахаар боллоо.

2022 оны 03-р сард аймгийн ИТХ-аас улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төсвийн хүрээнд хийгдсэн ажил, 2022 оны цагаатгалын үйл ажиллагаанд зарцуулахаар тусгагдсан төсвийн судалгааг 27 сумаар нэгтгэн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүлэв.

## **ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:**

### **Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:**

Сумдын ИТХ-ын дарга засаг дарга нарын нэгдсэн сургалт семинарыг 03 сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулж, 2022 оны “Ногоон хөгжил баялаг бүтээгчдийг дэмжих жил” урианы жилийн нээлтийн арга хэмжээ, сумдын 2021 оны ажлын үр дүнгийн шагнал гардуулах ёслол, 2022 онд сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулж, 2022 онд анхаарч ажиллах ажлын чиглэл, үүрэг даалгавар, мэдээ мэдээлэл өглөө.

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар аймгийн ЗДТГ, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 29 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт уламжилсан.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 03 сарын 14, 28-ны өдрүүдэд танхимаар 2 удаа зохион байгуулж, нийт 22 үүргийг тэмдэглэлээр холбогдох байгууллага, суманд хүргүүлээ. Нэгдсэн шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг тооцож, зарим байгууллага, сумдын мэдээллийг дараагийн шуурхай зөвлөгөөний үеэр мэдээллийг сонсож, тайлбар авч ажиллаж байна.

Аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөг 6 хавсралтаар 283 арга хэмжээтэй буюу Засаг даргын зөвлөлийн хурлын хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар 120,

сургалт, семинар, зөвлөгөөний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар 53, нээлттэй хаалганы өдөрлөгийн төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар 34, орон нутаг, хэлтэс агентлагуудад хийгдэх хяналт-шинжилгээ үнэлгээ, шалган туслах ажлын төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар 30, багийн иргэдийн нийтийн хуралд оролцох хуваарийг тавдугаар хавсралтаар 12, байнгын ажиллагаатай салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааны тайлан хүлээн авах жагсаалтыг зургаадугаар хавсралт 34 арга хэмжээтэйгээр аймгийн Засаг даргын 2022 оны А/178 дугаар захирамжаар батлуулав.

“Цахим-Төв аймаг” төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын даргын 2022 оны А/164 дүгээр захирамжаар батлуулан холбогдох судалгаа тооцоо хийж эхлээд байна.



Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн эмч, техникийн ажилтангууд Япон Улсын Тоттори мужийн Төв эмнэлэгийн эмч, техникийн ажилтангуудаас гемодиализийн чиглэлээр цахимаар зөвлөгөө авсан. Япон Улсын Изүмисана хот болон Төв аймгийн бага ангийн сурагчдийн дунд зохиогдсон гар зургийн уралдааны шилдэг оролцогчдыг шалгаруулав.

Япон улсын Тоттори муж, Төв аймгийн найрамдалт харилцааны 25 жилийн ойн хүрээнд хийгдэх үйл ажиллагааны талаар Тоттори мужийн гадаад харилцааны мэргэжилтнүүдэд цахимаар танилцуулав.

2020 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн 45 улс төрийн албан тушаалтанд 6 сарын цалинтай тэнцэх тэтгэмжийг аймгийн Засаг даргын захирамжаар олгов.

**Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн чиглэлээр:**

Салбар зөвлөлийн 2022 үйл ажиллагааны төлөвлөгөөний 1 дүгээр улирлын хэрэгжилтийг тооцоход 38.26 хувийн биелэлттэй байна. (100%-1, 70.0%-2, 50.0%-2, 30.0%-18, хугацаа болоогүй-9)



Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөл, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчлан сэргийлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, зөв харилцаа хандлагыг төлөвшүүлэх шинэ санал санаачилгыг дэмжих замаар албан хаагчдын ёс суртахуунд эерэг нөлөө үзүүлэх зорилготой “Зөв хандлага-Эерэг нөлөө” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулахаар зарлалаа. Энэ жилийн хувьд аяны үргэлжлэх хугацаа 6 сар болж, "Авлигын эсрэг хамтдаа-Таны эрх, таны оролцоо" дэвтрийг 29 агентлаг, 27 суманд давхар аялуулж байгаагаараа онцлог юм. Аяны хүрээнд төрийн байгууллагууд дотооддоо 6 төрлийн арга хэмжээг зохион байгуулна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолоор баталсан **“Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу 210 иргэний нөөцийн бүртгэл, мэдээллийг шинэчлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.**

| № | Нөөцийн бүрэлдэхүүн  | Нөөцөд байгаа иргэний тоо |
|---|--|---------------------------|
| 1 | Ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэний нөөц /2019-21, 2020-94, 2021-72/   | 187                       |
| 2 | ТӨАТ-ны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаал эрхэлж байсан албан хаагчийн | 2                         |

|   |   |    |
|---|---|----|
|   | удирдах албан тушаалтны нөөц  |    |
| 3 | Төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөц   | 18 |
| 4 | Төрийн албаны тухай хуулийн 62.1.4-т заасан болон ЦАХЭЗБ-ын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээдофицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөц | 3  |

Тайлант хугацаанд нөөцөд бүртгэлтэй иргэдийн мэдээллийг 2 удаа дотоод удирдлагын систем (e-office)-ээр нийтэд төрийн байгууллагуудад хүргэсэн, 3 иргэнд нөөцөд бүртгэлтэй лавлагаагаар үйлчиллээ. 1 дүгээр улиралд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх тусгай шалгалтаар 30 иргэн ажлын байраар хангагдсан бөгөөд үүнд ТЖАХ-аас 2, ТЖАХ-ийн нөөцөөс 4, 2019 оны нөөцөөс 2, 2020 оны нөөцөөс 8, 2021 оны нөөцөөс 14 иргэн байна.




Бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан Орон нутгийн өмчийн газрын 4 албан тушаалд чиг үүргийн өөрчлөлт орж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулах зөвшөөрөл ирүүлснийг хянаж, бүрдэл хангуулан ТАЗ-д хүргүүлсэн.

Төрийн албаны нөөцийн бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, төрийн албаны шалгалтад бэлтгэж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “И ЭС ЭЙЧ” сургалтын байгууллагатай хамтран 2022 оны 03 дугаар сарын 11-ээс эхлэн 10 хоногийн эрчимжүүлсэн сургалтыг Зуунмод хотод зохион байгууллаа. Тус сургалтад 30 иргэн хөнгөлттэй үнээр хамрагдсан.



2022 оны 1 дүгээр сарын байдлаар салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 22 тогтоол гаргасан бөгөөд дундажаар 80.45%-ийн биелэлттэй байна.



Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг танилцуулбал:

| № | Төрөл                 | Нийт тоо | Үүнээс хариутай | Шийдвэрлэсэн | Хүлээгдэж буй | Шийдвэрлэлтийн хувь |
|---|-----------------------|----------|-----------------|--------------|---------------|---------------------|
| 1 | Ирсэн албан бичиг     | 108      | 87              | 81           | 6             | 93.1%               |
| 2 | Ирсэн өргөдөл, гомдол | 9        |                 | 7            | 2             | 77.7%               |
| 3 | Явсан албан бичиг     | 54       | 42              | 22           | 20            | 52.4%               |

ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалтыг өссөн дүнгээр 11 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамрууллаа.



“Стратегийн баримжаатай хүний нөөцийн удирдлага” сургалт зөвлөгөөний үеэр Төв аймаг дахь салбар зөвлөлөөс төрийн албаны шинэтгэлийн хүрээнд хийж буй онцлог ажил, арга туршлагын талаарх мэдээллийг ТА3 болон бусад 20 аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн 30 гишүүн, албан хаагчид танилцуулж, мэдээлэл өглөө.



Канад улсын Мерит төслийн техникийн зөвлөх Мишелл Карлзены Төв аймагт ажиллах томилолтын хугацаанд дараах албан хаагчдад арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгууллаа.

- Салбар зөвлөлийн 3 гишүүнд төрийн байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- 6 байгууллагын дарга, нэгжийн даргад "Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээ, хөгжлийн төлөвлөлт", "Зан төлөвт суурилсан ярилцлага"
- 26 хэлтэс, агентлаг, байгууллагын удирдах албан тушаалтанд "Санал шүүмжийг бодитой өгөх ур чадвар", "Зан төлөвт суурилсан ярилцлага хийх ур чадвар" сэдвээр сургалт
- "Төв HR" клубын 25 гишүүн буюу байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтний чөлөөт уулзалт



Монгол Улсын Их Хурал, Төрийн албаны Зөвлөл, Канадын Засгийн газрын дэмжлэгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл, Лебириал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан хамтран зохион байгуулсан "ТЭГШ БОЛОМЖ-ХАМТЫН ҮР ДҮН" төрийн захиргааны эмэгтэй албан хаагчдын анхдугаар чуулганд Төв аймгаас 2 төлөөлөл оролцлоо.



Салбар зөвлөлөөс Төрийн албаны хууль тогтоомж, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр 6 удаагийн сургалт хийхэд давхардсан тоогоор 128 байгууллагын 732 ажилтан, албан хаагч хамрагдлаа.

Төрийн албаны зөвлөлөөс 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн албаны нөөц бүрдүүлэх ерөнхий шалгалтыг зохион байгуулахаар товлосон. Энэ удаагийн шалгалтыг Төв аймагт өгөхөөр 254 иргэн бүртгүүлсэн. Салбар зөвлөлийн 2022 оны 22 дугаар тогтоолоор ерөнхий шалгалтыг зохион байгуулах салбар комисс, ажлын хэсэг байгуулагдаж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, ажил үүргийн хуваарь гарган ажиллаж байна.



Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.6-д заасны дагуу төрийн захиргааны 165 (удирдах 7, гүйцэтгэх 158) сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 2 удаа зохион байгуулсан. Шалгалтын нийлбэр дүнгээр нийт зарлагдсан ажлын байрны 18.2% нь нөхөгдөх боломжтой болж хамгийн өндөр оноотой 30 оролцогч (үүнээс эрэгтэй 6, эмэгтэй 24)-ийг тухайн албан тушаалд нэр дэвшүүллээ.



## **Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах, төрийн үйлчилгээний хүрээнд:**

2022 оны 03 дугаар сард аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **19** байгууллага **500 гаруй** төрлийн үйлчилгээг **4274** иргэнд, өдөрт дунджаар **150-200** иргэнд хүргэн үйлчилж байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн систем /E-mongolia/- ийг нэвтрүүлж энэ сарын 14-18-ний өдрүүдэд Харилцаа холбоо, мэдээлэл технологийн яамны И-Монгол академийн ажлын хэсэг манай төв ажиллаж 2 шатлалт 58 төрлийн үйлчилгээг шинээр нэмсэнээр тус төв нь **18** байгууллагын **214** төрлийн нэг болон олон шатлалт үйлчилгээг игэдэд үзүүлэх боломжтой болсон. 3 сарын байдлаар E-mongolia нэгдсэн системээр дамжуулан 03 сард аймгийн хэмжээнд **797** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас **284** лавлагаа үйлчилгээ авсан.

Харин Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **6** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан 100 хувь гүйцэтгэлтэйгээр шийдвэрлүүлсэн. Одоогийн байдлаар хугацаа болоогүй **3** гомдол байна.

Мөн байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаар дамжуулан нийт **51** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **25** иргэн машины татвар, торгууль төлөх, үүрэн телефоны нэгж авах, төлбөр төлөх зэрэг үйлчилгээнүүдийг авсан.

Үүнээс гадна ЦХМТЯамны И-Монгол академийн “Цахим жишиг-Төв аймаг” нээлттэй өдөрлөг болж 57 хүн, Төрийн банкны албан хаагчдын богино хугацааны сургалт болж 12 хүн хамрагдсан бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарилгаар тэрбум мод тарих аяны хүрээнд “Зуунмод цэцэрлэгжүүлэлт” ОНӨААТУҮГ-аас Үйлчилгээний нэгдсэн төвийн нийт албан хаагчдад Ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт, цэцэрлэгжүүлэлтийн талаар сургалт зохион байгуулсанд 18 албан хаагч хамрагдсан.

## **МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Газрын даргын тушаалаар батлагдсан хуваарийн дагуу /ковид-19/ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд шуурхайн штабын хариуцлагатай жижүүрийн үүргийг гүйцэтгэж, худалдаа үйлчилгээний газрууд, ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

### **Нэг. Иргэн, аж ахуй нэгжийн өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу хийгдсэн шалгалт:**

“МИАТ” Төрийн Өмчит Хувьцаат Компанийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Мэргэжлийн хяналтын газар ирүүлсэн 06/252 дугаартай хүсэлтийн дагуу газрын даргын баталсан 19/01 дугаартай удирдамжийн хүрээнд Сэргэлэн сумын Хөшгийн хөндий дэх “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын зорчигчдын хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулдаг Нүхт тур ХХК-ийн хоол бэлтгэх үйл ажиллагаа, Зуунмод сумын 1 дүгээр багт үйл ажиллагаа явуулдаг Жаргалант хүнсний дэлгүүрт хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт бус шалгалт хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 13 заалттай 2 албан шаардлага, 19-02-005/09 дугаартай эд зүйлийг шилжүүлэх 1 актыг үйлдэж Сэргэлэн сумын Засаг даргын дэргэдэх Орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

5 аж ахуйн нэгж байгууллагын тарих үрийн чанарын талаар Итгэмжлэгдсэн лабораторид 15 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулсан. Бүтээгдэхүүний тухай 1 дүгнэлт, улсын байцаагчийн 5 заалттай зөвлөмж хүргүүлж ажилласан.

Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 12, малын эмийн сан 4, эрчимжсэн аж ахуй 5, эрүүл ахуй халдвар хамгаллын хяналтын чиглэлээр ундын

усны эх үүсвэр, хог хаягдал-5, халуун усны үйлчилгээ-5, хүнсний чанар аюулгүй байдлын хяналтын чиглэлээр хүнсний худалдаа-30, хоол үйлдвэрлэл-30, хүнсний үйлдвэр-10, ургамал хамгаалал хорио, цээрийн хяналтын чиглэлээр газар тариалангийн үйлдвэрлэл-40, нийт 3668 заалт бүхий 141 зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. ОХУаас импортоор Сүмбэр Сэргэлэн сумдад орж ирсэн үржлийн адууны хорио цээрийн дэглэмд хяналт тавьж байна.

Төв аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хоригдол, хоригдогчийн хоолы илчлэгийн тооцооны аргаар бодож улсын байцаагчийн Илчлэг тооцсон тухай 2 дүгнэлтийг хүргүүлсэн. Барилга байгууламжийн зураг төсөлд урьдчилсан хяналт хийх тухай газрын даргын баталсан 19/12 дугаартай удирдамжийн хүрээнд 4 дүгнэлт гаргасан

Төв аймгийн Заамар сумын Хайлааст 3 дугаар баг “Баянголын ам”-ын иргэн Гэрэлийн Мөнхжаргалын Төв аймгийн Мэргэжлийн хяналтын газарт гаргасан гомдлын дагуу 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Бүрдэл майнинг ХХК”-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Геологи, уул уурхайн салбарын болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчин болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг Төв аймгийн нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 63 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.

Төв аймгийн 27 сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарт Байгаль орчин, геологи, уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны багц хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэх, нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг хүргүүлсэн.

Төв аймгийн нутаг дэвсгэрт газар эзмшигч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 74, барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 21, банкны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 4, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 1, нийт 100 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хамтарсан, 27 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, Газрын даамал нарт эрх бүхий албан тушаалтан эрх, үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор зөвлөмж тус тус хүргүүлээд байна.

Заамар суманд Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Тэнхун ХХК, Пирамтдпрогресс ХХК-ийн талбайд гарсан 2 үйлдвэрлэлийн ослын мэдээллийг МХЕГ-ын холбогдох газрын дарга, ахлах байцаагч нарт яаралтай мэдээллэх хуудсын дагуу болон цахим хаягаар хүргүүлэн, актыг хянаж байна. ДЭХГ-ын 160 ажилтан, албан хаагчдад албан хүсэлтийн дагуу үйлдвэрлэлийн осол, эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын сургалтыг амжилттай зохион байгуулж ажилласан.

Хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн, Геологи, уул уурхайн салбарын болон холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг хангах, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчин болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг Төв аймгийн нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 21 аж ахуй нэгж байгууллагад, 4 банкинд улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг хүргүүлсэн.

Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 19 аж ахуйн нэгж байгууллагад хамтарсан зөвлөмж, 2 аж ахуй нэгж байгууллагад бие даасан зөвлөмж хүргүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд цацрагийн дэвсгэр түвшинд хяналт шинжилгээ хийх, Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үнсэнд хяналт шинжилгээ хийх, Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын хувийн тунд хяналт шинжилгээ хийх тухай 3 удирдамж батлуулан ажилласан. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 01/25 дугаартай Төв аймгийн нэгдсэн эмнэлэгт төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчлгээ үзүүлэх удирдамжийн дагуу



хамтран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хамтарсан зөвлөмж өгч ажилласан. Байгууллагаас зохион байгуулсан. “Харилцан хүндэтгэе жендер ба хүний эрх”, “Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй ба хүний эрхийг хүндэтгэх нь” сэдэвээр сургалтанд суусан.

Монгол улсын Засгийн газрын 318 тогтоолын дагуу Төв аймгийн Баянчандмань сумын 260 хүний суудалтай соёлын төвийн болон Баянцагаан сумын 4-р багт “Мандах бадрах булан” ХХК-ний “Camel oil” ШТС-ийн барилга байгууламжийн хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө ба үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг хангуулж байна.

Төв аймаг дахь Цагдаагийн газрын барилга байгууламжийн ашиглалтын байдалд шалгалт хийн, ашиглалтын төлөв байдлын тухай улсын байцаагчийн 3 дүгнэлт, ашиглалтыг зогсоох тухай 1 акт тус тус боловсруулж, хүргүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын хууль, Геологи, уул уурхайн салбарын болон холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг нэмэгдүүлэх, байгаль орчин болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагыг дээшлүүлэн ажиллах талаар улсын байцаагчийн хамтарсан зөвлөмжийг Төв аймгийн нутаг дэвсгэрт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг 74 аж ахуйн нэгжид хүргүүлсэн.

Барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 21, банкны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 4, холбооны шугам сүлжээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 7 нийт 32 аж ахуйн нэгжид улсын байцаагчийн хамтарсан зөвлөмж тус тус хүргүүлсэн.

Төв аймгийн Цагдаагийн газраас харьяаллын дагуу шилжин ирсэн хориотой ан буюу тарвага тээвэрлэсэн гэх 7 иргэнд 2.100.000 торгууль, 12.580.000 нөхөн төлбөр оногдуулан, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд 37 тооны тарвагыг шилжүүлсэн, зөшөөрөлгүй 89 шуудай байгалийн ургамал арц тээвэрлэсэн 2 иргэнд 300.000 торгууль, зохих зөвшөөрөлгүй 80 ширхэг загас тээвэрлэсэн 1 иргэнд 300.000 торгууль, 320.000 нөхөн төлбөр, таван толгойн сайжруулсан түлш тээвэрлэсэн 3 иргэнд 300.000 торгууль оногдуулан, 89 шуудай арц, 80 ширхэг загасыг улсын байцаагчийн актаар хураан авч Зуунмод сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлэн ажилласан.

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 18 дээжинд 56 үзүүлэлт / гүний усны 11 сорьцонд 33, төвлөрсөн системийн ус 3 сорьцонд 9, хоол 2 сорьцонд 2, бохир ус 2 сорьцонд 12 / үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан.

Эрүүл ахуй химийн лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 16 сорьцонд 78 үзүүлэлтээр / ундны усны 5 сорьцонд 65 үзүүлэлтээр, хоолны 10 сорьцонд 10 үзүүлэлтээр, талх талхан бүтээгдэхүүн 1 сорьцонд 3 үзүүлэлтээр / эрүүл ахуй химийн шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан байна.

Нэгж лабораториудад нийт 34 сорьцонд 134 үзүүлэлтээр шинжилгээг хийж үр дүнг цаг хугацаанд нь хянаж, баталгаажуулан гаргасан.

### **ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:**

Монгол Улсын Шадар Сайдын баталсан “Олон улсын иргэний хамгаалалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” болон “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах” нэгдсэн арга хэмжээний ажлын удирдамжийн дагуу төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газраас 2022 онд дэвшүүлсэн “Офицерын манлайлал, бие бүрэлдэхүүний сургалт, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх” зорилтын хүрээнд Онцгой байдлын газрын офицер бүрэлдэхүүн алба хаагчид руу чиглэсэн “МИНИЙ АЛБА-МИНИЙ БАХАРХАЛ” арга хэмжээг зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачлагаар хэрэгжиж байгаа “Илүүдэл жингүй-эртэч Монгол” аянд нэгдэн Онцгой байдлын газрын алба хаагчид 7 хоног бүрийн лхагва гараг бүрт өглөөний алхалт, дасгал хөдөлгөөнийг хийж эхлээд байна.

Онцгой байдлын газрын офицер ахлагч бүрэлдэхүүнд танхимын сургалтыг 7 удаа 14 цагийн сургалтаар давхардсан тоогоор 210 алба хаагчийг хамруулан зохион байгууллаа.

Гамшиг, осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол улсын Шадар сайдын баталсан нэгдсэн удирдамжын хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламжид шалгалтыг зохион явуулав.

Шалгалтад Төв аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 12 байгууллага хамрагдсанаас гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 68 зөрчил илэрч, газар дээр нь 16 зөрчлийг арилгуулж 52 зөрчилд хугацаат үүрэг даалгавар, ЗБАШ-6-г, МЭДЭГДЭЛ-3-г бичиж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн тусалж, сургалт, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 32 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 167 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 79 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгсөн.

Аймгийн хэмжээнд баригдах 11 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичсэн. Хяналт шалгалтад хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 21-н аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, 2 зөвшөөрөл олгосон.

Аймгийн шуурхай штабт 4 удаа 96 цагийн үүрэг гүйцэтгэж, иргэдээс ирсэн мэдээ мэдээллийг цаг тухай бүрт шийдвэрлэж, мэдээ тайланг явуулсан.

Нийт 5 гал түймрийн тохиолдол дээр ажилласан.

Мал амьтны гоц халдварт өвчин:

Аймгийн хэмжээнд 2022 оны 03 сарын 30-ны өдрийн байдлаар Малын гоц халдварт шүлхий өвчний 2 голомт үргэлжилж байна.

Сэргэлэн сумын 5-р багийн нутаг Аршаварт гэх газар өвөлжиж байгаа Б.Бямбасайхан, А.Наранцэцэг нарын 2 өрхөөс 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуудлага өгсний дагуу нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 96 үхэр, 1669 хонь, 410 ямааг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 2 айлийн 4 үхэр, 120 хонь өвчилсөн. Голомтын бүсийг 10 км-ээр тогтоож, 5 албан хаагч суурин 1, хөдөлгөөнт 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

Аргалант сумын 2 дугаар баг Цагаан хөтөл суурин гэх газар өвөлжиж байгаа Т.Батзоригийн 1 өрхөөс 2022 оны 02 сарын 07-ны өдөр дуудлага нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 13 үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 6 үхэр өвчилсөн. Голомтын бүсийг 5 км-ээр тогтоож, 2 албан хаагч суурин 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын алба хаагч нарт ангиллын 14 удаагийн 28 цагийн сургалтанд танхим болон цахим хэлбэрээр 454 ажилтныг хамруулсан.

Зуунмод сумын Засаг даргын Тамгын газартай хамтран 27 сумын малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж нийт 188 малчдад гамшиг ослоос урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал, аливаа гамшгийг хохирол багатай даван туулах чиглэлээр мэдлэг мэдээлэл олгохоос гадна

хаяг байршлын What3words системийг нийт хүмүүст танилцуулан хүн бүрийн утсан дээр суулгаж ашиглах аргачлалыг зааж өгөв. Тус сургалтад хамрагдсан малчдад нийт 386 ширхэг гарын авлага, тараах материал тараан ажилласан.

Гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг дээшлүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, уялдаа холбоог сайжруулах, эрсдэлийг даван туулах, мэдлэг чадвар, дадлага олгох сургалтыг Төв АЗЗА ТӨХК, Мэргэжлийн хяналтын газар, Авто тээврийн төв, Нийгмийн даатгалын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг Зуунмод сумын төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нийт 454 ажилтан, алба хаагчдыг хамруулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах, байгууллагын эрсдэлийг бууруулах, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар болон Гамшгаас хамгаалах тухай хуулиар цахим болон танхимын дадлага сургалт зохион байгууллаа. Сургалтад хамрагдсан нийт ажилтан, алба хаагчдад нийт 956 ширхэг гарын авлага, тараах материал тараан ажилласан.

Аймгийн TBS телевизтэй хамтран ажиллах гэрээг 1 жилийн хугацаанд байгуулж цаг агаарын сэрэмжлүүлэх шторк, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх шторк, коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллүүд бэлтгэн ажиллаж байна.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 68 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 29 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 5 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 5 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 16 удаа нийт 26 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

### **ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:**

Аймгийн удирдлагууд болон Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 30 хэлтэс, агентлаг, харьяа байгууллагын дарга нараас авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах “МЭДЭГДЭЛ” гаргуулж хэвлэл мэдээлэл, цахим орчноор дамжуулан олон нийтэд сурталчиллаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/134 тоот “Сум, байгууллагад архивын баримтад тооллого явуулах тухай” захирамжийн дагуу 27 сум, 28 байгууллагад цахим сургалт зохион байгуулж, 68 чиглэл зааварчилгаа өглөө.

Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаартай холбогдуулан иргэд, хувийн хэвшлийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/121 дүгээр захирамжаар иргэд, худалдаа эрхлэгчтэй уулзалт зохион байгуулж, аймгийн хэмжээнд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах Ажлын хэсэг байгуулав.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/149 дугаар захирамжаар “Зөв хандлага-эерэг нөлөө”, А/155 дугаар захирамжаар “Архигүй үлгэрлэе” сэдэвт 6 сарын аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулж байгаатай холбогдуулан сум, байгууллагад чиглэл өгч ажиллалаа.

Аймгийн хэмжээнд хэрэглээний соёлыг дээшлүүлэхээр зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч аян”-ыг 2022 оны 3 дугаар сарын 01-нээс 21-нийг хүртэл цахимаар зохион байгуулж 54 байгууллага оролцлоо.

Алтанбулаг, Баянчандмань сумын төрийн байгууллагын албан хаагчдад шинээр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг сурталчлах, эрх зүйн мэдлэг олгох, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор хуулийн сэдэвчилсэн сургалтыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран зохион байгуулж нийт 103 албан хаагчийг хамруулж, 34 иргэнээс үйлчилгээний байгууллагын талаар сэтгэл ханамжийн судалгаа авч, хэрэглэгчийн эрх, хэрэглээний соёлын талаар бэлтгэсэн 3 төрлийн 140 ширхэг гарын авлагыг 90 иргэнд тараалаа.

Зуунмод, Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг шатахуун түгээх станцын үйл ажиллагаа болон шатахууны үнийн асуудлаар хяналт шалгалт хийж Улаанбаатар хотын шатахууны үнийг харьцуулсан судалгааг гарган иргэдийг мэдээ, мэдээллээр хангалаа.

Лүн, Сэргэлэн, Сүмбэр сумын нотариатчийн үүргийг хавсран гүйцэтгэгч нарт нотариатын үйлдэл хийхэд анхаарах асуудлаар арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Төв аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр 12 улсын 152 гадаадын иргэн (хөдөлмөр эрхэлж буй 118, хөрөнгө оруулагч 10, цагаач 3, хувийн бус зорилгоор 19, түр ирэгч 2) оршин сууж байна.

Говь-Алтай аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн архивын тасгийн албан хаагчид манай аймагт зочилж, аймгийн Засаг даргын Тамгын газрын, Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн архивын тасаг, Нэгдсэн үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцлоо.

#### Төрийн архивын тасгийн үйл ажиллагаа:

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 233 иргэний хүсэлтийг хүлээн авч 1375 хуулбар хувь, 112 лавлагаа, 284 сан хөмрөгийн 1191 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж, орон нутгийн төсөвт 2.0 сая төгрөгийг орууллаа.

4 хөмрөгийн 30 хадгаламжийн нэгжийн 2952 хуудас баримтын 13527 хүний нэрийг скайнердаж программд оруулан 4516 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр Борнуур, Улаанбаатар-Дарханы чиглэлийн аглаг бүтээлийн хийд хүртэлх 6,2 км хатуу хучилттай авто замын 29 баримтыг хүлээн авч хадгаламжийн сангийн бүртгэлд авлаа.

#### Улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 61586 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 11102 газар өмчлөх эрхийн 50434 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1185. (3 сард хүлээн авсан мэдүүлэг-1185)

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 1360 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 91.8 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2.9 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 79 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 45 нэмэлт өөрчлөлт, шинээр 78 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 1, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 24 бүртгэл хийгдсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 4 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 41 лавлагаа өглөө. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого 10.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 208 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 79 хэргээр буюу 61,2 хувиар өссөн. Гэмт хэргийн илрүүлэлт 38 хувьтай байна.

Гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй зэрэг зөрчил гаргасан 57 иргэнээс 18 иргэнийг эрүүлжүүлж, 39 иргэнийг баривчилгаанд, 6 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч ажиллалаа.

2022 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүртэл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 90 жолоочийг илрүүлж, 61 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодон хөдөлгөөнд оролцсон 29 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлууллаа.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4831 жолоочийг 151.2 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 62 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:

Криминалистикийн шинжилгээ-59, магадлан шинжилгээ-70, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-149, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-404, гарын хээний санг дардсаар баяжуулсан-283, мөрөөр баяжуулсан-38, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-227, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-67, гистологийн шинжилгээ-61 тус тус хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:

| Гүйцэтгэлийн бодит биелэлт | Оны эхний үлдэгдэл | Шинээр нэмэгдсэн | Хасагдсан | Биелүүлбэл зохих | Бодитой биелүүлсэн | Үлдэгдэл  | Дундаж хувь |
|----------------------------|--------------------|------------------|-----------|------------------|--------------------|-----------|-------------|
| 03-р сар                   | 217                | 176              | 3         | 390              | 136                | 254       | 34.9        |
|                            | 4587209.8          | 715760.7         | 131567.3  | 5171403.2        | 1109913.7          | 4061489.5 |             |

**ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:**

**Хөрөнгө оруулалт:** Аймгийн хэмжээнд 2022 онд 59,469.8 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 59,314,7 сая төгрөгийн 85 төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө. 2022 оны 3 дугаар сарын байдлаар нийт 38 /УТХО-8, ОНТ-29/ төсөл арга хэмжээний тендер зарлаж, гүйцэтгэл 44.8 хувьтай байна.

**Худалдан авах ажиллагааны талаар зохион явуулсан ажил:** Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг нийтэд ил тод болгох ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) сайтуудад байршуулан ажиллан ажиллаж байна.

**Барилга, хот байгуулалтын чиглэлээр:** 2022 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 40 төсөл арга хэмжээ төсөвт өртөг 79274,3 сая төгрөг, 2022 онд 29013,8 тэрм бум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн чиг үүрг гүйцэтгэж байна.

Улсын хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж байгаа 7 барилга байгууламж 9232,8 сая төгрөг, 2022 онд шинээр эхлэх 23 барилга байгууламж 16386,4 сая төгрөг -Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамжиж байгаа 5, 2022 онд шинээр 5 барилга байгууламж, их засвар 3232.5 төгрөгийн ажил хийгдэж байна.

Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Төв аймаг 5 удаагийн ажил хэргийн уулзалтыг зохион байгууллаа. Үүнд:

- Зуунмод хотод ажиллаж Зуунмод хотод 2022 онд хэрэгжүүлэх Баруунзуунмод, Баянхошуу дэд төв, 2 дахь 1000 айлын дэд бүтэц, 25.1 гад Баатруудын цэцэрлэгт хүрээлэн, усан бассейн, А бүсийн явган засын замын зураг төсөв болон барилга угсралтын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний талаар мэдээлэл, хэлэлцүүлэг хийж, инженерийн шугам, сүлжээний асуудлаар газар дээр нь танилцаж, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэлээ.

- Хөшгийн хөндийн 600 айлын орон сууц барих ажлын хэсэг хуралдаж, архитектур төлөвлөлтийн даалгавар олгох талаар хэлэлцсэн.

- Угтаалцайдам суманд ажиллаж, иргэд олон нийттэй суманд хэрэгжих “Сумын хөгжил: инженерийн дэд бүтцийн хангамж төсөл” хэлэлцүүлэг зохион байгууллаа.

**Хот байгуулалтын кадастрын чиглэлээр:** Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд 6 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан ба энэ сард 6 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Зураг төсөл боловсруулах даалгавар нийт 30 олгосон. Зураг төсөл зөвшөөрөлцөх баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. 2022 онд 9 зураг төсөл зөвшөөрөлцсөн. 3 дугаар сард нийт 9 зураг төсөл батлаад байна.

Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл ашиглалтад оруулах үйл ажиллагааны чиглэлээр Барилга эхлүүлэх зөвшөөрөл нийт 5 олгож, барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд 2 барилга байгууламж ашиглалтад орсон.

### **ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

**Суурь судалгаа газрын мониторингийн ажлын хүрээнд:** 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Батсүмбэр 6, Баянхангай 7, Баянчандмань 18, Цээл 4, Эрдэнэсант 4, нийт 39 нэгж талбарын газрын дуудлага худалдааны зарыг [www.mle.mn](http://www.mle.mn) сайтад баталгаажуулсан. Баянжаргалан, Зуунмод сумын 5 нэгж талбарт ирсэн төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж ялагчийг тодрууллаа.

**Газрын төлбөр:** 2022.02.24-ний өдөр батлагдсан аймгийн ИТХ-ын 12 дугаар “Газрын төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” тогтоол “Хууль зүй, дотоод хэргийн яам”-д бүртгэгдэж ирсэн. Тогтоолын итгэлцүүрийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэлийг үүсгэн ажиллаж байна. Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмын төслийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээ.

**Газрын кадастрын чиглэлээр:** Газрын кадастрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлтийн ажил зохион байгуулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд Газрын даргын 2022.03.14-ний А/08 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулж, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумдад нөхөн бүрдүүлэлтийн ажлаар ажиллалаа.

Засгийн газрын 307 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай байгаа нэгж талбарын хувийн хэрэг, холбогдох материалын жагсаалтын дагуу

БХБСайдын 2021 оны 270 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэгт хүлээн өгөх ажлыг Сэргэлэн сумын иргэн, хуулийн этгээдийн 1277 нэгж талбарыг мэдээллийн дагуу Сэргэлэн сумын Засаг даргын захирамжаар 232 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 247,14 га газрыг хүчингүй болгосон.

Төв аймгийн нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэнд 2022 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор шинээр өмчлүүлэх газрын хэмжээг 4709 иргэнд 1420,25 га, улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх 559 иргэнд 39,13 га, эзэмших эрхээр олгогдсон газрыг өмчлүүлэх газрын хэмжээг 931 иргэнд 65,06 га, аж ахуйн зориулалтаар иргэнд үнээр өмчлүүлэх 1 иргэнд 0,17 га, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар үнээр өмчлүүлэх 40 иргэнд 0,7 га-гаар тус тус баталсан байна. Үүний дагуу 2022.03.30-ны 07/255 албан бичгээр сумдын Засаг дарга, Газрын даамал нарт зөвлөмж, чиглэл өглөө.

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР**

**Өмчийн хүрээнд:** Аймгийн ИТХ-ын VIII хуралдааны 2022.02.24-ны өдрийн 14 дугаар тогтоолын дагуу 2 барилга, 8 тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг холбогдох хууль журмын дагуу нээлттэй зарлан, 03 дугаар сарын 24-ны өдрийн дуудлагын худалдаагаар 1 барилга оролцогчгүй болж дахин нээлттэй зарлан явуулахаар болж, 1 барилга, 8 тээврийн хэрэгслийг борлуулж, Аймгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд 123,4 сая төгрөгийг төвлөрүүллээ.

Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой 230 хуулийн этгээдийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлангуудыг хүлээн авч нэгтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хуулийн хугацаанд нь тайлагнасан. Мөн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны үйл ажиллагааны тайлан хүргүүллээ.

**Түрээсийн орон сууцны хүрээнд:** Аймгийн “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлж, нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, 2022 оны 03 сарын байдлаар 25 айлын түрээсийн төлбөр 4,416,015 төгрөгийг түрээсийн орон сууцны санд төвлөрүүллээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төсвөөс 1.5 тэрбум төгрөг батлагдаж, “Төрийн албан хаагчийг орон сууцжуулах”, “Түрээсийн орон сууц” төслийг хэрэгжүүлж тендер зарлах шатанд явагдаж байна. Мөн Зуунмод сумын 80 жилийн ойг угтаж, төрийн албан хаагчдын 90 айлын орон сууц төслийг хэрэгжүүлж эхэллээ.

### **ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР**

**Мал аж ахуйн хүрээнд:** Мал аж ахуйн салбарын хаваржилтын хүндрэлээс урьдчилан сэргийлэх, мал төллөлт, төл хүлээн авах бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг боловсруулж, 27 сумдад чиглэл хүргүүлэн ажиллалаа.

Аймгийн хэмжээнд 2.2 сая толгой хээлтэгч мал төллөхөөс 5.4 хувь буюу 124274 толгой хээлтэгч мал төллөж, 124916 толгой төл гарсны 99.7% буюу 124550 толгой төл бойжиж байна.

Борнуур, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Архуст, Зуунмод, Цээл сумдын малчдын болон төлчин эмэгтэйчүүдийн зөвлөгөөнд оролцож бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, малын үүлдэр, угсааг сайжруулах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр мэдээлэл хийсэн.

2021 оны ноосны урамшуулалд хамрагдах материалаас 377 малчны нэр, дансны зөрүү засварлан ХХААХҮЯаманд хүргүүллээ.

“Аймгийн нутагт дэвсгэрээр отрын мал дамжин өнгөрөх журам”-ын төсөлд 27 сум, 11 аймаг, ХХААХҮЯам, мэргэжлийн байгууллагад санал авах хүсэлтийг хүргүүлснээр мэргэжлийн 4 байгууллага, 15 сум санал ирүүлж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаад байна.

**Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд:** Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1585.0 мян.тол мал хамруулахаар төлөвлөн, эм биобэлдмэлийн татан авалт 17.3 хувьтай байна.

Тайлант хугацаанд 6207 мал, амьтан, 184.5 тн мах, махан бүтээгдэхүүн, 1225 ширхэг арьс шир, 821.4 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 0.16 кг ноолуур, 1.2 тн дайвар бүтээгдэхүүнд 1001 мал эмнэлгийн гэрчилгээ олгож, 1121 малд үйлчилгээ үзүүллээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 146 тээврийн хэрэгсэл, тэмээ 26, адуу 61, хонь 315, ямаа 50 толгой, нийт 452 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 488.1 тн, 19227 ширхэг арьс шир, 20 тн ноос, 6.0 тн дайвар бүтээгдэхүүнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж 1 зөрчил илрүүлэн арилгуулж ажиллалаа.

**Газар тариалангийн хүрээнд:** 2022 онд үр тариа 96.0 мян.га, үүнээс улаанбуудай 89.0 мян.га, таримал тэжээл 30.0 мян.га, төмс 10.0 мян. га, хүнсний ногоо 1.6 мян. га-д талбайд тариалж, 398.5 мян.тонн ургац хураан авах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Төмсний үр шинэчлэх зорилгоор Аймгийн хөгжлийн сангаас 150.0 сая төгрөгийн итгэлийн зээлийг 9 сумын тариалан эрхлэгчдэд олгож, 5 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж гала сортын элит I репродукцийн 208 тн төмсний үр нийлүүлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд 2021 оны хураан авсан ургацаас нийт 59 иргэн, аж ахуйн нэгжийн борлуулагдаагүй 17292.5 тн улаанбуудайн судалгааг ХХААХҮЯаманд хүргүүлж, улаанбуудайн дээж авч шинжилгээнд хамрууллаа.

Архуст, Баяндэлгэр, Борнуур, Дэлгэрхаан сумдад зохион байгуулсан “Малчдын зөвөлгөөн” оролцогч 600 гаруй малчдад бэлчээрийн нөхөн сэргээх арга туршлага, өвөлжөө хаваржааны хөлд тэжээл тариалах, таримал тэжээл тариалах бэлтгэх мэдээлэл, зөвлөгөө өглөө.

**Үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд:** Аймгийн Засаг даргын 2022 оны А/94 дугаар захирамжаар “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2.1 заасны дагуу тэргүүлэх чиглэл батлан, 27 суманд үүрэг чиглэл өгч ажиллалаа.

ХХААХҮЯ-ны ЖДҮГазартай хамтран хоршооны талаар баримтлах хууль, хэрэгжүүлж буй арга хэмжээ, “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг орон нутагт хэрэгжүүлэх цахим сургалтын ХХААХҮЯ-ны ЖДҮГ-тай хамтран зохион байгууллаа. Тус сургалтад 27 сумын ЗДТГ-ын дарга, Санхүү төрийн сангийн мэргэжилтэн, хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 425 иргэн оролцлоо.

Мөн Төрийн банктай хамтран “Зээлийн боломж хамрагдах нөхцөл” сургалт зохион байгуулж 38 бизнес эрхлэгчдийг хамрууллаа.

Уул уурхайд түшиглэсэн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, баялаг бүтээгчид хамтын ажиллагаа сайжруулах сургалтын МЕРИТ төсөлтэй хамтран 2 удаа зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 34 иргэнийг хамруулан чадавхижууллаа.

Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 9 сумын 16 иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг хянан Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй болголоо.

### **СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт ажлын хүрээнд:** Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулах Зуунмод, Сэргэлэн, Угтаал, Цээл, Заамар сумдын 67 иргэн, аж ахуйн нэгжийн хүсэлтийг тохирлын үнэлгээнд хамруулан ажиллалаа. Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн 2022 оны 03 дугаар хурлын хэлэлцүүлэн 64 аж ахуйн нэгж иргэний 52 худалдаа, 7 нийтийн хоол, 1 үсчин, 2 дэн буудал, 1 зочид буудал, 1



амралтын газрын үйлчилгээнд тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаагаар шинээр олгох сунгахаар шийдвэрлэлээ.

**Хэмжил зүйн лаборатори:** Хэмжил зүйн лаборатори нь Хэмжил зүйн лаборатори нь 6 суманд ажиллаж хэмжлийн 2 төрлөөр нийт 86 ширхэг хэмжих хэрэгслийг баталгаажууллаа.

### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

**Ойн талаар:** Ногоон хөгжил- Баялаг бүтээгчдийг дэмжих жилийн ажлын хүрээнд, Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон -Төв аймаг” ойн анхдугаар зөвлөгөөнийг 2022.03.05-ны өдөр зохион байгууллаа. 2030 он хүртэл манай аймаг 20 сая мод тарих бөгөөд аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа 27 сумын Засаг дарга болон аж ахуй нэгж байгууллагуудтай хариуцлагын гэрээ байгууллаа. “Ногоон- Төв аймаг зөвлөгөөнд” Байгаль орчны аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, яамны газрын дарга нар болон 27 сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагчид, Сум дундын ойн ангиуд, ойн нөхөрлөлүүд, байгаль орчны чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл нийт 300 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Зөвлөгөөний үеэр мод, модон материалын болон үр, тарьц суулгац, багаж, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн гарган ажиллалаа.



Дэлхийн усны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, цас хайлж байгаатай холбогдуулан усны сан бүхий газар, уст цэг, төв зам болон нийтийн эзэмшлийн талбайд бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах ажлыг 03-р сард аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

2022 онд Дэлхийн усны өдрийг “Газрын доорх ус” сэдвийн хүрээнд иргэд, хүүхэд залуучуудад танин мэдэхүйн мэдлэг мэдээлэл олгох, газрын доорх усыг хайрлах, хэмнэх чиглэлийн мэдээллийг түлхүү хүргэж ажилласан. Алтанбулаг, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Лүн сумдад 200 гаруй сурагчдыг хамруулан газрын доорх усны талаарх хичээл, АХА тэмцээн зохион байгуулсан.



Б

аян-  
Өнж  
үүл,  
Алт  
анбу  
лаг,

Баяндэлгэр, Баянхангай, Дэлгэрхаан, Өндөрширээт сумдад 8 удаагийн бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, 409 иргэн, төрийн албан хаагчид оролцон 41 тн хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгт хүргэсэн байна.

**Уул уурхай, хяналт шалгалтын хүрээнд:** Заамар сумын нутаг дэвсгэрт Төв суурин газраас хол байдлыг ашиглан хууль бус алт олборлолт хийгдсэн гэсэн мэдээллийн мөрөөс аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Засаг даргын орлогч Г.Сурмаагаар ахлуулсан ажлын хэсэг газар дээр нь шалгалт хийлээ. Шалгалтаар 2008 оноос одоог хүртэл хууль бус гар аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааны улмаас хөндөгдсөн 70 гаруй нүхний талбай болон гүний хэмжээг тогтоон цаашид хэрхэн хамгаалах талаар орон нутгийн удирдлага болон цагдаагийн албан хаагчидтай уулзаж ярилцав.

## **УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

**Урьдчилан мэдээлэх:** Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм, өдөр тутмын цаг агаарын мэдээг [www.tuv.tsag-agaar.gov.mn](http://www.tuv.tsag-agaar.gov.mn) сайт, TuvTsaguur page-д байршуулан, 27 сумын ОНИМ-ийн ажилтанд и-мэйл болон “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна.

**Байгаль орчны шинжилгээний лаборатори:** Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 03 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар нийт 46 удаа ажиглалт хийсэн.

### **ТАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Алдарт эхийн 1, 2 дугаар одон шинээр авах 27 сумын 369 эхийн материалыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас хүлээн авч, баримт бичгийн бүрдүүлэлтэд хяналт хийж, шаардлага хангасан 369 эхийн материалыг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал болон АИТ-ийн хурлаар хэлэлцүүлэн Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлэх бэлтгэл ханган ажиллаж байна.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний сайхан ээж 1000”-хүндэтгэлийн арга хэмжээг ТББ-тай хамтран зохион байгууллаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр “Харилцан хүндэтгэе” үндэсний аянд нэгдэн АЗДТГ-ын даргын 03 дугаар сарын 04-ний өдрийн 02\393 тоот албан бичгээр аймгийн төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж Хүний эрхийн үндэсний комиссын Төв аймаг дахь салбар, Мерит төсөл болон хамтрагч байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд жендэрийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх 151 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, 30351 хүнд эерэг мэдээ, мэдээлэл түгээж ажиллалаа.

Орон нутгийн мэргэжлийн боловсролын салбар зөвлөл 2022 оны анхдугаар хуралдаанаа 03 дугаар сарын 30-ны өдөр цахимаар зохион байгуулж 2022-2023 оны хичээлийн жилд элсэгчдийн хяналтын тоог хэлэлцэн батлууллаа.

Зуунмод сумын ИТХ, ЗДТГ-аас баг, сургууль, цэцэрлэг, харьяа байгууллагын нийт 13 байгууллагын 389 төрийн албан хаагчдад хийсэн сургалт зөвлөгөөнд оролцож хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, цаашдын чиг баримжаа, хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар мэдээлэл хийлээ.

Коронавируст /Ковид-19/ халдварын цар тахлын дэгдэлтийн үед хүнд ачаалалтай ажиллаж, хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан Эрүүл мэндийн салбарын үйлчлэгч, жолооч нарт хүндэтгэл үзүүлэх “**ТАНД БАЯРЛАЛАА**” 2 удаагийн арга хэмжээг аймгийн ЗДТГ, Эмэгтэйчүүдийн холбоо, Монгол туургатан театртэй хамтран зохион байгуулж, аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 108 үйлчлэгч, ариутгагч, 50 жолооч хамрагдлаа. Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед идэвхтэй ажилласан үйлчлэгч, жолооч нарт хүндэтгэл үзүүлж, Засгийн газрын болон аймгийн ИТХ, аймаг, сумын Засаг даргын шагналаар 49 алба хаагчийг шагнаж урамшууллаа.

#### **Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:**

Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургууль цэцэрлэгт нийлүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнн, тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтийг гаргаж БШУЯ-нд хүргүүллээ.

Аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу БШУГ-аас сумдын сургууль, цэцэрлэгт зөвлөн туслах ажлын удирдамж батлуулан Зуунмод сумын Хүмүүн цогцолбор сургууль, 4-р сургууль, Хүмүүн, Дэгдээхэй, Бүжинхэн, Унагалдайн андууд, Бумбардай цэцэрлэг болон Жаргалант, Сүмбэр сумын сургууль цэцэрлэгүүдийн 18 удирдах ажилтан, 229 багш, 4560 суралцагч, 324 эцэг эхийг хамруулан зөвлөн тусаллаа.

ЭЭШ-д бэлтгэх ажлын хүрээнд 12 жилийн сургалттай сургуулиудын 12-р ангийн сурагчдаас сорилын шалгалт авч дүнг нэгтгэхэд гүйцэтгэлийн хувь 36%-тай байна.

“Хичээл судлагдахуун бүрээр сургалтын чанарыг дээшлүүлье-VI” аяны календарчилсан төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж байна.

Суралцагчдын эзэмшвэл зохих агуулгын хоцрогдлыг бүх анги, судлагдахуунаар нийт суралцагчдыг хамруулан оношлох, гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, АДШ, УШ, Чанарын үнэлгээний шалгалтад бэлдэх, суралцагчдийн хоцрогдлыг нөхөх, арилгах ажлын үр дүнг сургуулийн түвшинд тодорхойлох ажлын хүрээнд явцын үнэлгээ хийх хуваарь гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **Соёл, урлагийн газрын хүрээнд:**

СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуультай хамтран МУ-ын Ардын багш С.Дуламын цомнол, МУ-ын УГЗ Д.Баярбаатарын дэглэлт, Төрийн соёрхолт С.Соронзонболдын хөгжим “Босоо цагаан гурвалжин” үндэсний орчин үеийн бүжгэн жүжгийг 03 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Монгол туургатан театрт Зуунмод сумын иргэд, хүүхэд залуучуудад толилууллаа. Хүүхэд багачууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үнэ төлбөргүй хамрууллаа.

Аймгийн Соёл, урлагийн газраас Нийтийн номын сан, аймгийн Музейн албан хаагч нартай уулзалт зохион байгуулж “Соёл, урлагийн газар”-ын бүтэц дүрэм болон үйл ажиллагааны чиглэл, төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг танилцуулан тухайн байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.

Соёлын яамнаас зохион байгуулж буй мэргэжлийн урлагийн байгууллагын хөгжим болон гэрлийн техник хариуцсан албан хаагчдыг “Орчин үеийн хөгжмийн тоног төхөөрөмжийг хэрхэн зөв ашиглах чадвар, мэдлэгийг эзэмшүүлэх” сургалтад 03 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн Улаанбаатар хотод хамруулж эхлээд байна.

2022 оны 1 дүгээр улиарлд Соёл, урлагийн байгууллагуудаас 119 төрлийн урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 21480 иргэнд хүрч үйлчлээд байна.

Аймгийн Монгол туургатан театраас 2 шинэ уран бүтээл туурвиж 9 сая төгрөгийн санхүүжилт зарцуулж, 15 сая төгрөгийн орлоготой ажиллалаа, сумдын 18 соёлын төвөөс шинээр нийт 33 концерт тоглож 3.882.000 төгрөгийн санхүүжилт зарцуулан мөн 11.547.300 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

#### **Аймгийн Нийтийн номын сан:**

Аймгийн нийтийн номын сангаас “Ухаарлаас ургасан бодол” яруу найргийн уралдааныг 27 сумдын ЕБС-ийн 8-12 ангийн сурагчдын дунд зохион байгуулж 75 яруу найрагч хүүхэд оролцсоноос эхний байранд шалгарсан 4 хүүхдийг шагнаж урамшууллаа.

Сум, сургуулийн номын санчдыг чадавхжуулах сургалтыг “Номын сангийн орчин үеийн чиг хандлага” сэдвээр зохион байгуулж, сургалтад 62 албан хаагч оролцож **93, 3%** нь сургалтад хамрагдлаа.

Эхний улирлын байдлаар аймгийн Нийтийн номын сан нь танхимаар 1232 байнгын уншигч, 2547 ирэгсэд нийт 3779 уншигчдад 7048 ном олгож үйлчиллээ. Зөврийн номын сангаар сумдад нийт 243 иргэнд 484 номоор үйлчиллээ.

#### **Аймгийн Монгол Туургатан театр:**

Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллага Монгол туургатан театраас МУ-ын СГЗ Ш.Гүрбазарын зохиол “Шар гэгээ” драмын жүжгийг шинээр найруулан тавьж үзэгчдэд толилуулан “Гэгээн муза” наадамд өрсөлдөхөөр шалгаруулалтын баг бүрэлдэхүүнд толилууллаа.

Их зохиолч Д.Нацагдоржийн зохиол, Төрийн хошой шагналт ардын жүжигчин Билэгийн Дамдинсүрэнгийн хөгжим “Учиртай гурван толгой” дуурийг МУСТА Ц.Батнайрамдалын найруулгаар дахин тайзнаа амилж, Нансалмаагийн дүрд “Монгол туургатан театр”-ын дуучин, МУСТА Л.Нарангэрэл, Юндэнгийн дүрд “Монгол туургатан театр”-ын дуучин, МУСТА

Б.Дашпүрэв, Балганы дүрд “Монгол туургатан театр”-ын дуучин, МУСТА П.Баярмагнай, Хоролмаагийн дүрд “Монгол туургатан театр”-ын дуучин, МУСТА Э.Мөнгөнчимэг нар тоглож үзэгчдийн хүртээл болголоо.

**Аймгийн Музей:**

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн улсын болон аймгийн хамгаалалттай түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрын улсын тооллогыг зохион байгуулж дууслаа.

Эхний 1 улирлын байдлаар боловсролын хөтөлбөрийн хүрээнд Зуунмод сумын Ерөнхий боловсролын сургуулийн 7, 8-р ангийн нийт 16 бүлгийн 417 сурагчдад “Манзуширын хийдийн түүх, соёлтой танилцах”, “Угийн бичгийн тухай, угийн бичиг хөтлөх арга” сэдвээр танхимын сургалтыг зохион байгуулсан. Эхний улирлын байдлаар нийт 963 иргэн музейгээр үйлчлүүлсэн байна.

27 сумын соёлын төвөөс давхардсан тоогоор нийт 9938 иргэнд, 84 төрлийн арга хэмжээг хүргэж үйлчиллээ.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний талаар:**

2022 оны 03 дугаар сарын байдлаар 1790 иргэнд 1518,6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1180 иргэнд 198,5 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1005 иргэнд 233,5 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 14 иргэнд 16,8 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9361 эхэд 1215,1 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5623 ахмад настанд 453,5 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 330 ахмад настанд 66,4 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 89 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 24,2 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 170,0 сая төгрөг, жирэмсэн 587 эхэд 67,3 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4289 эхэд 607,2 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 299 эх /эцэг/-т 125,8 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 8 ихэр хүүхдэд 16,0 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 2 иргэнд 3,0 сая төгрөг, 33779 хүүхдэд 10104,7 сая төгрөгийг давхардсан тоогоор 63794 иргэнд 14820,6 сая төгрөгийг тус тус олгосон.

**Нийгмийн хөгжлийн чиглэлээр:**

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрх, өрхийн гишүүн иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг ОНОТХҮ-ний бүлгийн төсөл ирүүлэх тухай албан бичгийг сумдын Засаг даргад хүргүүлж, 8 сумын 26 төсөл хүлээн авсан. Холт ОУБ-ын дэмжлэгээр хэрэгжиж байгаа “Хүүхдийн амьжиргааг дэмжих” хөтөлбөрт хамрагддаг 43 өрхийн 50 хүүхдийн 1 дүгээр улирлын явцын тайлан судалгааг төслийн зохицуулагч нартай хамтран 35 хүүхдээс авч 15 хүүхдийн судалгааг авч хүргүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2022 оны 03 дугаар сард 2 удаа хуралдаж 15 хүүхдийн хөгжлийн бэрхшээл, 13 хүүхдийн байнгын асаргааг сунгаж ажилласан.

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 03 дугаар сарын байдлаар 6 ажил олгогч, 48 ажил хайгч иргэн бүртгэгдлээ.

Шинээр бий болсон 24 шинэ ажлын байрыг бүртгэн мэдээллийн санд оруулсан. Нийт 18 ажил олгогчийн 47 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 32 (нийт 85) иргэн ажилд зуучлагдлаа. Түр ажлын байранд ажилласан нийт 183 (нийт 189) иргэнийг бүртгэж мэдээллийн санг үүсгэн ажиллалаа. “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудалд үйл ажиллагаа явуулдаг СУ сүлжээ дэлгүүрийн хүний нөөцийн албатай хамтран ажил горилогч иргэдтэй ажлын байрны ярилцлагыг 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж 10 иргэн ярилцлагад орж 6 иргэн ажилд зуучлагдсан. Сэргэлэн суманд үйл ажиллагаа явуулж буй

Монбийф ХХК-ний ажлын байрны захиалгын дагуу 3 иргэнтэй VIBER аппликейнш ашиглаж ярилцлага зохион байгуулж 1 иргэнийг ажилд зуучилсан.

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:**

Тайлант хугацаанд 33 иргэний 21946.3 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрч, өссөн дүнгээр 218 иргэний 75829.8 мянган төгрөг төвлөрсөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт өссөн дүнгээр Лел металл, Илт Гоулд, Уулс Заамар зэрэг ХХК-аас 7 иргэний 29524,2 мянган төгрөг ХЭДСанд төвлөрсөн байна.

**Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу арилжааны 2 банкаар 15908 тэтгэвэр авагчдад 8.1 тэрбум төгрөгийн 3 сарын тэтгэврийг хуулийн хугацаанд нь олгов. Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсан 125 иргэнд 12 сая төгрөг, жирэмсэн амаржсан 90 эхэд 166.3 сая төгрөг, 15 иргэний ар гэрт оршуулгын тэтгэмж 15 сая төгрөгийг нийт 226 даатгуулагчид 178.3 сая төгрөгийн тэтгэмжийг олгон ажиллалаа. Ажилгүйдлийн даатгалын сангаас 31 иргэнд 71.9 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах хуваарийн дагуу 2022 оны 03 дугаар сарын 29-нд Жаргалант суманд зохион байгуулж иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажилласан.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 3 удаа нийт 185 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 22 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 151 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 12 иргэнийг цуцалсан байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын чанар хүртээмжийг сайжруулах, магадлалын үйл ажиллагаанд оролцогчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэдээ, мэдээлэл хүргэх зорилготой Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эмнэлэг хөдөлмөрийн манадлах төв комиссоос хамтран “Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож буй бодлого зохицуулалт” сэдэвт бүсчилсэн сургалтад 2022 оны 03 дугаар сарын 10-14-ны хооронд Дархан-Уул аймагт ЭХМК-ын орлогч дарга, магадлагч эмч, дотрын болон мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн эмч нар хамрагдлаа.

**Эрүүл мэндийн даатгалын талаар:**

2022 оны 02 дугаар сард даатгуулагч иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн 78 эрүүл мэндийн байгууллагаас нийт 25 төрлөөр нэхэмжлэлийг хүлээн авч чанарын хяналт явуулж, санхүүжилт олгох зөвшөөрлийг ЭМДЕГ-т илгээсэн.

**Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах “Цодгор хүү-2022” тэмцээнийг амжилттай зохион байгуулж 12 сумын 19 багийн 84 шатарчид 24 багц медалийн төлөө өрсөлдөж аваргаа шалгаруулсан.

Тэмцээний багийн дүнгээр I байранд 1 алт, 2 мөнгө, 2 хүрэл медалиар Борнуур, II байранд 1 алт, 2 мөнгөн медалиар Зуунмод сумын “Хос Алтан бэрс” клуб, III байранд 2 алт медалиар Эрдэнэсант сумдууд тус тус шалгарсан байна. Тэмцээнд Тэргүүн байр эзэлсэн 8 тамирчид Улсын аварга шалгаруулах “Цодгор хүү-2022” тэмцээнд оролцох эрхтэй болсон.

ГБХЗХГ-ын дэргэдэх “Хүслийн жигүүр” бүжгийн дугуйлангийн сурагчид “Уран хэлхээ” улсын IX наадамд цэнгээнт бүжиг, Монгол бүжгийн төрлөөр оролцож “Гранпри” шагналыг хүртэж амжилттай оролцсон.

“Харилцан хүндэтгэе” үндэсний аяны хүрээнд Залуучууд хөгжлийн төвтэй хамтран “Хайр дүүрэн Гэр бүл” өдөрлөгийг Зуунмод сумын Зүүндэлгэр 4-р багт 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгөөр “ГЭР БҮЛ АМГАЛАН БОЛ ХҮҮХЭД ЖАРГАЛТАЙ” сэдэвт сурагчдын гар зургийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, эрсдэлт зан үйлд

нөлөөлөх “ХОРТ ЗУРШИЛГҮЙ ӨРХ” өрхийн төсвөө хэрхэн зөв зарцуулах чиглэлээр “ӨРХИЙН ТӨСӨВ БА ЗОХИЦУУЛАЛТ” сургалтуудыг тус тус 18 эцэг, эхэд зохион байгуулж гарын авлагаар хангасан.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн баярыг тохиолдуулан Жендэрийн үндэсний хорооноос “Харилцан хүндэтгэе” сарын аяныг 03 дугаар сарын 1-ээс 04 дүгээр сарын 1-ний хооронд орон даяар зарласан. Аяны хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр Жендэрийн эрх тэгш байдал, хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, гэр бүлийн харилцаанд тулгарч буй эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг арилгах зорилгоор 6 багийн 20 эмэгтэйд Жендэрт суурилсан хүчирхийллийг өөгшүүлж буй нийгмийн тогтсон хандлагад нөлөөлөх зорилготой хэлэлцүүлэг зохион байгуулсан.

“Харилцан хүндэтгэе” үндэсний аян, Монгол цэргийн баярыг тохиолдуулан 03 дугаар сарын 18-ны өдөр аймгийн ДЭХГазрын 160 гаруй ажилтан, албан хаагчдад “Гэр бүл дэх эр хүн, эцэг хүний үүрэг хариуцлага” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Аймгийн Цагдаагийн газар, Залуучууд хөгжлийн төвтэй хамтран зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Гэр бүл дэх эр хүн, эцэг хүний үүрэг хариуцлага” сэдвээр Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан 15 хүмүүжигчид зохион байгууллаа.

#### **Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах “Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал” сэдэвт Үндэсний чуулганыг угтаж дэд хэлэлцүүлгийг ЗХТ хариуцан аймгийн Эрэгтэйчүүдийн холбоотой хамтран 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдөр ГБХЗХГ-ын их танхимд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт аймгийн ЭМГ, ХХҮГ, ГБХЗХГ, ШШГГ, ЦГ, ОБГ, БОАЖГ, ХХААГ, Татварын хэлтэс, Музей, Полтехникийн коллеж, Ирээдүй цогцолбор, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо болон иргэд, малчдын төлөөлөл нийт 72 хүн оролцлоо Тус хэлэлцүүлгээр “Эрэгтэйчүүдийн манлайлал, үлгэр дуурайлал, оролцоо”, “Эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх” сэдвийн хүрээнд Гэр бүл дэх эр хүн, эцэг хүний үүрэг хариуцлага, Эрэгтэйчүүдийн нийгэмд үзүүлэх эерэг хандлага, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, боловсролын асуудлуудлаар мэргэжлийн байгууллагууд мэдээлэл хүргэж, эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал, түүнээс гарах арга замын тухайд хэлэлцэн, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж, уриалгыг Засгийн газрын зөвлөмжид тусгуулахаар хүргүүллээ.

2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан Үндэсний чуулганд Төв аймгаас ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжийн төвийн ажилтнаар ахлуулсан “Эрэгтэйчүүдийн холбооны тэргүүн”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргүүн” Бизнес эрхлэгч, малчдын төлөөлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.

Залуучуудын хөгжлийн төвөөс Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, цэргийн баярыг угтаж Зэвсэгт хүчний 016-р анги нэгтгэл, Монгол шуудан ХК хамтран “ХАЙР ШИНГЭСЭН ЗАХИДАЛ” арга хэмжээг зохион байгууллаа. Хугацаат цэргийн 100 алба хаагчдын сэтгэлийн үг, баярын мэндчилгээг захидлаар дамжуулан ар гэр, хайртай дотны хүмүүст нь илгээлээ.

#### **Эрүүл мэндийн талаар:**

Аймгийн хэмжээнд 2022 оны 2 дугаар сарын байдлаар 112 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 93 тохиолдлоор буурсан ба 115 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад нийт 718 эмэгтэй байна, 209 жирэмсэн эмэгтэйг шинээр хяналтад авснаас эхний 3 сартай хяналтад 88.04% хамрагдсан. Нийт 41020 хүнд үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 9934, амбулаторийн үзлэг 24753, идэвхитэй хяналтын 4284 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 2888 хүнд эрүүл мэндийн тусламж

үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 26.0%, осол гэмтлийн дуудлага 2.35%-ийг эзэлж байна. Стационарт 3066 хүн эмчлэгдэн нийт 25033 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 8,2 байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн дэргэд байгуулагдсан “Эрүүл мэндийг дэмжих төв”, Компьютерт томографын аппарат хүлээлгэн өгөх нээлтийн арга хэмжээг УИХ-ын гишүүн Ж.Батжаргал, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар болон ЭМЯ-ны удирдлага, аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалдорж, аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар болон албаны хүмүүс оролцон зохион байгууллаа.

ЭМЯ-ны захиалгаар СЭМҮТ-с “Жирэмсэн болон төрсний дараах үеийн сэтгэл гутрал түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох” нь сэдэвт судалгааны ажил зохион байгуулан, аймгийн нийт 94 жирэмсэн эхийг хамруулан, 54 жирэмсэн эхэд сахарын ачаалалтай сорил хийхэд чихрийн шижинтэй 4 эмэгтэйг илрүүлэн, хяналт, эмчилгээнд хамрууллаа.

ЭМЯ, ЭМХТөвтэй хамтран Сэргэлэн, Сүмбэр, Баянцагаан 3 сумын Эрүүл мэндийн төвийг цахимаар магадлан итгэмжлэлд амжилттай хамрууллаа, 16 СЭМТөвийг магадлан итгэмжлэлд хамруулахаар цахимд оруулсан мэдээлэлд хяналт хийн, зөвлөн тусалж ажиллаж байна.

Аймгийн Эрүүл мэндийн салбарын “Удирдах ажилтны зөвлөгөөн” Эрт илрүүлье-Эрт эмчилье уриан дор 2 өдөр амжилттай зохион байгуулж ЭМГ, АНЭ, 26 сумын ЭМТ, ӨЭМТ-ийн 48 удирдах ажилтан хамрагдлаа. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийн салбарын санхүүжилт, хүний нөөц чиглэлээр салбар хуралдаан зохион байгуулан, хэлэлцүүлэг хийж зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг 2022 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Зөвлөгөөний үеэр “Ковид 19” цар тахлын хүнд нөхцөлд өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, ард олноо аюулт өвчнөөс авран хамгаалахад мэдлэг, ур чадвар, хүч чадлаа дайчлан амжилттай ажилласан зарим албан хаагчид, албан байгууллага, 2021 оны үндсэн үйл ажиллагаагаараа тэргүүлсэн сумдын Эрүүл мэндийн төвүүдийг шагнаж урамшууллаа.

Төв аймгийн Сумын эмч мэргэжилтний холбоо байгуулан, анхдугаар чуулган зохион байгуулж 22 сумын Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтний төлөөлөл 37 хүн оролцлоо.

2022 оны 03 дугаар сард Коронавируст халдвар /Ковид-19/-ын нийт батлагдсан тохиолдол 265 бүртгэгдэж тандалт хариу арга хэмжээ авч ажиллалаа.

Баян, Баянцагаан, Сэргэлэн сумдад сүрьеэгийн үзлэг зохион байгуулж нийт 500 гаруй иргэдийг хамруулан 3 сүрьеэгийн тохиолдол илрүүлсэн.

ЭМЯ, Яаралтай тусламжийн амилуулах нийгэмлэгтэй хамтран Сүмбэр, Эрдэнэ, Баянхангай, Дэлгэрхаан суманд 26 сумын ЭМТ, 4 сувиллын эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 4 удаагийн бүсчилсэн сургалтыг “Яаралтай тусламжийн цогц менежмент” сэдэвт онол дадлага хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 200 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулан багц цаг олгож чадавхжууллаа.

#### **Биеийн тамир спортын чиглэлээр:**

Төв аймагт БТС-ын байгууллага үүсч хөгжсөний 70 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан 2022 оны өсвөр үе, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 01,02-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 20 сум, сургууль 3 холбоо нийт 23 багийн 291 тамирчид;

Өсвөр үе, насанд хүрэгчдийн 100 буудалт даамны ААШ тэмцээнд 10 сумын 180 тамирчид;

“Энх мэндийн харваа-2022” шагайн харвааны тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулагдаж 13 аймгийн 73 багийн 624 харваач;

2022 оны өсвөр үеийн боксын аймгийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд УБ хотын тулааны спорт сургалтын төвд зохион байгуулагдаж 8 байгууллагын 10 эм, 41 эр 51 тамирчин;

Аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн Баянчандмань суманд 2022 оны 03 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд өсвөр үе, насанд хүргэгчдийн насны ангиллаар зохион байгуулагдан 7 сумын 8 багийн 103 тамирчин;

Идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулагдан 9 сумын 18 багийн 162 тамирчин;

Төв аймгийн Баян-Өнжүүл сумын харьяат Монгол улсын Ардын Багш, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, улсын арслан Л.Сосорбарамын нэрэмжит 2022 оны Жүдо бөхийн Аймгийн аварга шалгаруулах тэмцээн 03-р сарын 17-18-ны өдрүүдэд болж 16 сумын эрэгтэй 148, эмэгтэй 112 нийт 260 тамирчин;

“Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг сурталчилах, аянд нэгдэж идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэгчдийг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг Алтанбулаг, Эрдэнэсант сумдад зохион явуулж нийт 183 иргэн;

МУ-ын гавъяат багш Ц.Гомбын нэрэмжит өсвөр залуучуудын чөлөөт бөхийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022.03.26-27-нд Лүн суманд зохион байгуулж 18 багийн 265 тамирчин тус тус оролцлоо.

2022 оны 03 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд Зуунмод хотноо Монголын хөлбөмбөгийн холбоодын удирдлагуудын чуулган болж аймаг, сумын удирдлагууд, 21 аймгийн Хөл бөмбөгийн холбоодын дарга нар оролцлоо.

Насанд хүрэгчдийн Цанын улсын аварга шалгаруулах тэмцээн Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт суманд зохион байгуулагдаж тамирчин А.Хүслэн, Г.Энхнасан, Т.Амарсанаа нар спортын мастер, тамирчин Н.Мөнгөнцэцэг спортын дэд мастерын болзлыг биелүүлж 3 мөнгө, 2 хүрэл медаль;

Жү-до бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.03.12-13-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдан 21 аймаг 9 дүүргийн 1500 гаруй тамирчид оролцож манай баг тамирчид 2 хүрэл медаль;

Боксын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд боксын Алтан Од клубын тамирчид амжилттай оролцож 2 хүрэл медаль хүртэж, тамирчин Б.Цэндсүрэн холимог тулааны тэмцээний 54 кг-ын жинд аварга;

Хэрэглэлгүй Пауэрлифтингийн өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.03.26-27-нд УБ хотноо зохион байгуулагдаж манай баг тамирчид амжилттай оролцож 3 алт, 4 мөнгө, 11 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр;

Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.03.26-27-нд Орхон аймагт зохион байгуулагдан манай баг тамирчид 2 алт, 2 хүрэл медаль хүртэн багийн дүнгээр тэргүүлэн улсын аварга баг боллоо.

Монголын Үндэсний олимпийн хорооны ерөнхийлөгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Наранбаатар "Олимпизм ба бие бялдрын хүмүүжил" сэдэвт болзолт уралдааны хүрээнд Төв аймгийн Зуунмод хотод ажиллаж Ерөнхий боловсролын сургуулиудын олимпийн танхим, БТСГ-ын үйл ажиллагаатай танилцлаа.

## **ЗУРГАА. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:**

### **Төсвийн орлогын талаар:**

Орлогын төлөвлөгөө эхний 2-р сарын байдлаар орон нутаг 2900,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 2299,6 сая төгрөг төвлөрүүлж 79,3 хувьтай, 600,7 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 185,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 2042,5 сая төгрөг төвлөрүүлж 1099,6 хувьтай, 1856,8 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 1648,5 сая төгрөгөөр биелж, 139,2 %-тай байна.

3-н шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр,



Угтаал, Цээл зэрэг 12 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Батсүмбэр, Баян, Баянхангай, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Жаргалант, Заамар, Лүн, Сэргэлэн, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 14 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баянцагаан зэрэг нийт 1 сум байна.

**Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

Сумдад 2022 оны 2 сарын байдлаар нийт 4238,3 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

-Сумдын ИТХ,ЗДТГазрын санхүүжилтэд 2091,6 сая төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 2146,7 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна

**Өр, авлагын талаар:**

2022 оны 2-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгуулагууд нийт 167,2 сая төгрөгийн авлага, 230.7 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 166,3 сая төгрөг буюу 72.0 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 2,9 сая төгрөг буюу 1.2 хувь нь цалин, НДШ-ийн өр, 10,8 сая төгрөг буюу 4.7 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 50,7 сая төгрөг буюу 22.1 хувийг бусад өр эзэлж байна

**ДОЛОО. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ХҮРЭЭНД:**

***Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:***

1. Монгол Улсын Хууль тогтоомж, бодлого, шийдвэр, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлэн 2021 оны нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээрээ шалгарсан Зуунмод, Алтанбулаг, Эрдэнэсант, Дэлгэрхаан, Баянчандмань сумд шагналыг гардууллаа.



2.Монгол Улсын их хурал 2021 оны 89 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор батлагдсан бодлого, хөтөлбөрийг дагаж аймгийн хэмжээнд батлагдсан бодлого, дэд хөтөлбөрийг хүчингүй болгох, шинэчлэн батлах саналыг ИТХ, ЗДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлууллаа.

2015-2021 онд аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн тогтоолоор 31 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө батлагдан, хэлтэс, агентлаг, сум, харьяа байгууллагууд хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнээс: хэрэгжих хугацаа дууссан 10, хүчингүй болгох саналтай 13, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 7, шинэчлэн боловсруулах шаардлагатай 4 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө байна.

2017-2021 онд аймгийн Засаг даргын захирамжаар 25 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө батлагдан, хэлтэс, агентлаг, сум, харьяа байгууллагууд хэрэгжүүлэн ажиллажээ. Үүнээс: хэрэгжих хугацаа дууссан 7, хүчингүй болгох саналтай 2, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 16 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө байна.

2022 оны 03-р сарын 11-12-ны өдрүүдэд 27 сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын “Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт эрчимжүүлэх нь” сургалт зөвлөгөөн болж Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Бодлогын баримт бичигт Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” арга зүй сэдэвт сургалт хийлээ.



Төв аймгийн Эрдэнэсант сумын төрийн албан хаагчдын "Ёс зүй, сахилга хариуцлага - манлайлал" V дугаар зөвлөгөөн зохион байгуулагдаж, тус зөвлөгөөнд сумын ЗДТГ, ЕБС, СӨБ, ЭМТ, Соёлын төв, Цагдаагийн хэсэг, УЦУОШТ-ийн нэгж, нийт 7 байгууллагын 170 гаруй албан хаагч оролцож, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс “Бодлогын баримт бичигт Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” арга зүй сэдэвт сургалт хийлээ.



Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар хэлтэс, агентлаг, харьяа байгууллагын дарга нартай 2022 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө үзэглэх ажлыг зохион байгууллаа.



Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн албан хаагчид манай аймагт зочилж аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаа болон Хяналт, шинжилгээ үнэлгээний мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцлоо.



**Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:**

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн ЗДТГ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Засаг даргын тусгай сан, ОНХС, Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, Зуунмод сумын Бүжинхэн, Дэгдээхий, Ирээдүй, Унагалдайн андууд, Хүмүүн цэцэрлэгүүд, 4-р сургууль, 5-р сургууль, Хүмүүн цогцолбор цэцэрлэг, Бумбардай цэцэрлэг, Зуунмод сумын ЗДТГ, ИТХ, Соёлын төв, Хот тохижуулах газар, Баруун Зуунмод БН ЭМТ-ийн 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 3,784,184.1 төгрөгийн зөрчил илрүүлж 86,134.6 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 511,059.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,186,989.7 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа. Өмнөх оны актын үлдэгдэл 171,193.5 мянган төгрөгөөс

41,336.1 мянган төгрөг, 2022 онд тогтоосон актаас 358.8 мянган төгрөг тус тус барагдсан байна.

### **НАЙМ. ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:**

Батлан хамгаалахын сайдын 2014 оны А/260 дугаар тушаалын 4.1.2 дахь заалт, Батлан хамгаалахын сайдтай аймгийн Засаг даргын 2022 онд хамтран ажиллах гэрээний 3.1.6, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газраас өгсөн чиглэл, үүрэг даалгаварыг дагуу Төв аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн А/125 тоот захирамж гарч уг захирамжаар “Монгол цэргийн өдөр” орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны яруу алдарт 101 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймаг болон сумдын иргэд, залуучуудад сурталчлах ажлын хэсэг байгуулан, тусгай төлөвлөгөө гарган төрийн цэргийн болон хуулийн байгууллагуудын харилцан ажиллагааг бэхжүүлэх, цэргийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор спортын тэмцээн уралдаан зохион байгуулан явуулж, иргэд олон түмэнд төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зэрэг арга хэмжээг орон нутагтаа зохион явууллаа.

**Нэг.** Монгол цэргийн өдөр, Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ойг тохиолдуулан аймгийн ЗДТГ, Цэргийн штабаас төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулж байгаа “Эх орны төлөө-2022” тэмцээн Зуунмод хотноо 3-р сарын 11, 12-ны өдрүүдэд аймгийн Бие тамир, спортын газарт зохион байгуулагдаж амжилттай дууслаа. Шагнал гардуулах арга хэмжээний төгсгөлд Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар баг, тамирчдад баяр хүргэж, үг хэллээ. Багийн нийт нийлбэр оноогоор Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл 1 дүгээр байр, Цагдаагийн газар 2 дугаар байр, ИТХ, ЗДТГ, Цэргийн штаб 3 дугаар байрыг тус тус эзэллээ.

**Хоёр.** Аймгийн Засаг даргын нэрэмжит марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн 2022 оны 03 дугаар сарын 14-15-ны өдөрүүдэд ЗХ-ний 016 дугаар нэгтгэлийн байнгийн байрлалд зохион байгуулагдаж, мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужилыг сорьсон тус тэмцээнд 7 байгууллагын 80 гаруй албан хаагчид оролцсон нь ур чадвар жилээс жил нэмэгдсэн байна.Тэмцээний “ТЭРГҮҮН БАЙР”-т Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт, Монгол улсын маршал Хорлоогийн Чойбалсангийн нэрэмжит Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн тасаг, Дэд байрт Зэвсэгт хүчний 334 дүгээр ангийн тасаг, Гутгаар байрт Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын тасаг, тусгай байрт Алтан гадас одонт, хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн тасаг шалгарсан.

**Гурав.** “Монгол цэргийн өдөр” Зэвсэгт хүчний 101 жилийн ойн баярыг тохиолдуулан Политехникийн коллеж, МСҮТ, Ерөнхий боловсролын сургуулиудын 7-12 дугаар ангийн сурагчдын дунд цахимаар “ЭХ ОРОН БОЛ МИНИЙ ИРЭЭДҮЙ” шүлгийн уралдаандыг зарласан. Нийт 35 сурагчдын бүтээл ирснээс цахим хандалт болон шүлгийн агуулга, уран уншилтаар шалгаруулж байр эзлүүлсэн.Тусгай байр эзэлсэн Зуунмод сумын 5 дугаар сургуулийн 11Б ангийн сурагч Б.Цолмон, 3 дугаар байрт Хүмүүн цогцолбор дунд сургуулийн 9ё ангийн сурагч Ш.Дэлгэрбаяр, 2-р байрт Заамар сумын 2 дугаар сургуулийн 8а ангийн сурагч Наранбуд, 1-р байрт Хүмүүн цогцолбор дунд сургуулийн 9ё ангийн сурагч Б.Энхжин нар шалгарлаа.

Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Зэвсэгт хүчний 016, 311, 119 дүгээр нэгтгэл, ангиудын хугацаат цэргийн албан хаагчдын дунд “ЦЭРЭГ ЭХ ОРНЫ” сэдэвтэй дууны уралдаанд 15 хугацаат цэргийн албан хаагч оролцож 3-р байр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байлдагч А.Нямдаваа, 2-р байр эзэлсэн Зэвсэгт хүчний 311 дүгээр ангиас оролцогч дэд түрүүч Г.Анхбаяр, 1-р байрт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн дэд түрүүч Э.Мөнгөнбагана нар шалгарлаа.

Мөн Төв аймгийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын албан хаагчдын дунд ЗДТГ-ын Цэргийн штаб, Элчис уран бүтээлийн нэгдэлтэй хамтран зохион байгуулж буй дунд зохион явуулсан “ХАМТЛАГ ДУУ”-ны уралдаанд 4-р байрт шалгарсан Онцгой байдлын газрын “Сүлд” хамтлаг, 3-р байрт Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн “Цэнхэр дуулга” хамтлаг, 2-р байрт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын “Сүлдэн заяа” хамтлаг, 1-р байрт Төв аймаг дахь Цагдаагийн газрын Цагаан шонхор” хамтлаг тус тус байр эзэлсэн.

**Дөрөв.** Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Төв телевизтэй хамтран Зэвсэгт хүчний 101 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан чөлөөнд байгаа ахмад дайчидтай “ДУРСАМЖИТ ЯРИА” телевизийн нэвтрүүлэг зохион байгуулж, нэвтрүүлэгт чөлөөнд байгаа бэлтгэл дэд хурандаа С.Очирбат, бэлтгэл хошууч Д.Хүрэлбаатар нар уригдан оролцлоо. Нэвтрүүлгийг Цэргийн баярын өдөр буюу 3 дугаар сарын 18-ны өдөр сошиал болон мэдээллийн суваг, телевизээр олон нийтэд хүргэсэн.

**Тав.** 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Төв аймгийн удирдлагууд, Хуурай замын цэргийн командлалын удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүн, Зуунмод хотын удирдлагууд, төрийн албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төлөөлөл Монгол улсын баатар Дуламдоржийн Самдан, Монгол Улсын баатар, хурандаа генерал Бутачын Цогийн хөшөөнд тус тус цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлсэн юм. Мөн Төрийн цэргийн болон хуулийн байгууллагын албан хаагчид их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит “Мөнх-Алдарын талбай”-д баярын ёслолын жагсаал зохион байгууллаа.

“Их булаг” цэргийн хүрээний анги, байгууллагын нэгдсэн туяа тооны үеэр, Зэвсэгт хүчин, анги байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан зурагт самбар, зэвсэг, техникийн үзэсгэлэн гарч, марш тактикийн тэмцээний аварга, тасгуудын жагсаалын болон гардан тулаан үзүүлэх тоглолтыг иргэдэд сонирхууллаа. Энэ үеэр Төв аймгийн Засаг даргын нэрэмжит Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээний шагналыг гардууллаа.

Монгол туургатан театрын их танхимд “Монгол цэргийн өдөр”-ийн баярын хурлын арга хэмжээг зохион байгууллаа. Хурлаар МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Батлан хамгаалах сайд, Аймгийн ИТХ, Засаг даргын шагналаар Төрийн цэргийн болон хуулийн байгууллагуудын албанд олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг цэргийн цол, төрийн одон медалиар шагнаж урамшууллаа. Арга хэмжээний төгсгөлд Монгол туургатан театр, ЗХ-ний 016 дугаар нэгтгэлийн алба хаагчдын хамтарсан уран бүтээлчдийн тоглолт боллоо.

**Зургаа.** Ойн баярын арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 3 дугаар сар 16-ны 14.00 цагт Монгол цэргийн өдөрт зориулсан хүчит бөхийн барилдаан зохион байгууллаа. Хүчит бөхийн барилдаанд аймгийн нутаг дэвсгэрт, үйл ажиллагаа явуулдаг Төрийн цэргийн болон хуулийн байгууллагын албан хаагчдын дунд сумын заан болон түүнээс доош цолтой 48 бөхийн барилдааныг аймгийн Цэргийн штабаас санаачлан зохион байгуулсан. Нээлтийн ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, Цэргийн штабын дарга дэд хурандаа Т.Төмөрчөдөр, ЗХ-ний 119 дүгээр ангийн захирагч хурандаа А.Бүрнээбаатар болон төрийн цэргийн байгууллагын удирдлагууд оролцлоо. Барилдааны түрүү бөхөөр ЗХ-ний 119 дүгээр нэгтгэлийн Завхан аймгийн Нөмрөг сумын харьяат сумын заан Ё.Гантулга түрүүлж, ЗХ-ний 119 дүгээр ангийн Хэнтий аймгийн Батноров сумын харьяат сумын заан С.Эрхэмбаяр үзүүрлэж, ЗХ-ний 016 нэгтгэлийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын харьяат сумын заан Н.Баярсайхан шөвгөрч, ЗХ-ний 016 нэгтгэлийн байлдагч Төв аймгийн Баян-Өнжүүл сумын харьяат залуу бөх Т.Алтаншагай уран барилдааны шагнал тус тус хүртлээ.